



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 21,630,000.00 (хорин нэгэн сая зургаан зуун гучин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ням-Очир, Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;


2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001895



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн
 8.79 дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөл	Сэргэн босголын зардал	Худалдах дээд үнийн санал
1	Мицубиши Делика, 28-32 УБК, суудлын, арал: P35W0601948	1996/2004	395,300	4,800,000.00	4,800,000.00	-	-	1,500,000.00
2	Ниссан Патрол, 05-04 УБО, суудлын, арал: NZ002738	1995/2001	483,700	16,830,000.00	16,830,000.00	-	-	2,000,000.00
Нийт дүн				21,630,000.00	21,630,000.00	-	-	3,500,000.00
				(хорин нэгэн сая зургаан зуун гучин мянган)				(гурван сая таван зуун мянган)